



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2025.06.06 № 0/1825

танай 2025.05.23-ны № 21 -т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА**

Танаас ирүүлсэн “Эрчим хүчний тарифын зохицуулалтын талаар” 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 21 тоот асуулттай танилцлаа.

Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.” гэж заасны дагуу холбогдох газраас ирүүлсэн мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт  хуудастай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ЧОЙЖИЛСҮРЭН



170600001042



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201

Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,

Цахим шуудан: info@erc.gov.mn

Цахим хуудас: erc.gov.mn

2025.06.06 № 011553
талай 2025.06.05-ны № 6/11795 -Т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Н.ТАВИНБЭХ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн “Эрчим хүчний тарифын зохицуулалтын талаар” 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 21 дүгээр асуулттай танилцлаа.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дулааны цахилгаан станц (ДЦС) төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд цахилгааны нийлүүлэх зориулалтаар өргөтгөлийн барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг 2016 онд, цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 2017 онд авч үйл ажиллагаа явуулж байна. Эрчим хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хэрэгцээнд ашиглах, экспортлох, гэрээний үнээр худалдахаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор цахилгааны тарифыг хянуулж батлуулахаар заасан болно.

Мөн Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3, 25.1.4-т санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх, уг тайланг аудитын байгууллагаар баталгаажуулан гаргаж өгөхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүрэг болгосон байдаг ба “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ДЦС санхүүгийн тайлан бүртгэлийг тусад нь хөтөлдөггүй, аудитаар баталгаажуулдаггүй тул тус станцын бодит өртөг, зардлыг тодорхойлж тарифыг хянах боломжгүй байдаг.

Иймээс Эрчим хүчний зохицуулах хороо нь тус станцын дотоод хэрэгцээний цахилгааны зарцуулалт, жишмэл түлшний хувийн зарцуулалт, нүүрсний илчлэг, ажиллагсдын орон тоо, үйлдвэрлэлийн технологийн болон ашиглалтын усны зардал, ашиглалтын цахилгаан, түүхий эд материал, шатахуун, материал хангамж, үл хөдлөх хөрөнгийн татвар, ажиллагсдын нийгмийн зардал зэрэг, үзүүлэлтийг тус станцын тарифын санал болон аудитаар баталгаажуагүй зардал, техникийн гүйцэтгэлээр, бусад зардал (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас хуваарилдаг дотоод тээвэр, ерөнхий удирдлага, үйлчилгээний хөлс гэх мэт) болон ажиллагсдын дундаж цалин, нүүрсний үнэ, төмөр замын тээврийн хөлс зэрэг, үзүүлэлтийг ижил төстэй ДЦС-уудын үзүүлэлт, гүйцэтгэлтэй жишиж тооцон 2024 оны тарифыг хянаж баталсан.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн төвийн бүсийн цахилгааны “Нэг худалдан авагч”-ийн санхүүгийн тайлангаас үзвэл 2024 оны гүйцэтгэлээр тус станцын нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн цахилгааны дундаж тариф 186.19 төгрөг/кВт.ц, ойролцоо хүчин чадал бүхий Дарханы ДЦС-ын дундаж тариф 188.09 төгрөг/кВт.ц, Эрдэнэтийн ДЦС-ын дундаж тариф 183.47 төгрөг/кВт.ц байна.

1425041499

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 2023 онд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Эрчим хүчний зохицуулах хороонд станцын өөрийн өртөг, зардлыг бодитоор тооцсон тариф шинэчлэн батлахыг даалгах тухай нэхэмжлэлийг гаргасны дагуу шүүгчийн 128/ШЗ2023/3216 дугаартай захирамжаар Захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд мөн оны 128/ШЗ2023/4841 дугаартай шүүгчийн захирамжаар тус станцын тарифын тооцоо нь үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурласан эсэхийг тодорхойлуулахаар шинжээч томилж, шинжээчийн дүгнэлт гарах хүртэл хугацаагаар хэрэг хянах шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлээд байна.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрчим хүчний тухай хууль, тусгай зөвшөөрлийн зохицуулалтаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь цахилгаан эрчим хүчээр хангах, хангагдах гэрээний дагуу Зохицуулах хорооноос баталж тогтоосон нийтээр дагаж мөрдөх хэрэглэгчийн тарифаар цахилгаан хэрэглэж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ДЦС нь үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифаар нэгдсэн сүлжээнд цахилгаан нийлүүлдэг ба цахилгааны биет хэмжээгээр суутган тооцох талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

ДАРГА



Э.ТҮВШИНЧУЛУУН